

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ
ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 9.15 дахь хэсэг нэмсүгэй.

“9.15.Зохицуулах зөвлөлд хот, суурины ус хангамж, ариутгах татуургын улсын байцаагч ажиллана. Улсын байцаагчийн эрхийг Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 10.4-т заасны дагуу олгоно.”

2 дугаар зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын байгууллага” гэсний дараа “болон эрх бүхий улсын байцаагч” гэж нэмсүгэй.

Гарын үсэг